



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 1302

Улаанбаатар хот

Олон улсын Ахмадын өдрийг тохиолдуулан
дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Чингэлтэйн ахмадууд-2028” арга хэмжээ батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Олон улсын Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	З.Бямбажав	Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Нацагдорж	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)
	Т.Батцэцэг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Г.Энхбаяр	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	П.Төвсанаа	Дүүргийн Ахмадын хорооны дарга
	Ж.Чимэдцогзол	Дүүргийн 3 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

2. Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

1525010879